



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2019

Э-сонин

74-р дугаар

9-Р САР






Зах зээлийн тойм


/2019.09.30-ны өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	21
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	3,192,663,246
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	2,597,429,296
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	595,233,950
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	14,211,902
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	14,206,026
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	5,876
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	3,808


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	198
100% төрийн өмчит	18
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	170
I ангилал	14
II ангилал	44
III ангилал	140

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	57
Үүнээс: Брокер, Дилер	51
Андеррайтер	19
Хөрөнгө оруулалтын зөвлөх	13



Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2019.09.30-ны байдлаар/

№	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	Ард секьюритиз ХХК	2,046,665	1,013,663,940	1,396,248	975,430,218	1,989,094,158
2	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	8,664,785	613,622,972	8,684,930	607,738,890	1,221,361,861
3	Гаүли ХХК	51,910	318,894,191	343,154	340,198,319	659,092,510
4	Новел инвестмент ХХК	78,021	329,566,508	74,453	169,276,135	498,842,643
5	Голомт Капитал ХХК	536,517	127,629,279	805,129	256,664,666	384,293,946
6	БиДиСек ХК	683,574	145,329,975	608,115	220,068,430	365,398,405
7	Ти Ди Би Капитал ХХК	235,477	72,236,662	807,306	220,852,189	293,088,851
8	Инвекор капитал ҮЦК	102,077	190,461,058	21,796	39,275,600	229,736,658
9	Бумбат-Алтай ХХК	752,138	108,488,911	378,039	118,231,919	226,720,830
10	Стандарт инвестмент ХХК	716,164	99,314,860	532,217	86,588,361	185,903,221
11	Лайфтайм инвестмент ХХК	10,665	67,375,750	400	2,600,190	69,975,940
12	Апекс Капитал ҮЦК	94,512	27,266,367	30,475	10,753,277	38,019,644
13	Батс ХХК	71,403	5,601,479	48,979	21,388,200	26,989,679
14	Эм Ай Би Жи ХХК	10,860	8,506,325	4,530	14,008,925	22,515,250
15	Ард капитал групп ХХК	8,348	2,732,378	113,635	18,511,733	21,244,111
16	Таван богд ХХК	0	0	29,719	20,431,075	20,431,075
17	Централ секьюритиз ҮЦК	27,583	11,296,760	38,530	8,727,549	20,024,309
18	Хүннү Эмпайр ХХК	9,305	7,740,703	11,084	6,484,858	14,225,561
19	Монсек ХХК	13,654	9,006,924	17,631	4,456,339	13,463,262
20	Зэргэд ХХК	13,343	7,488,859	12,583	5,867,901	13,356,760

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2019.09.30-ны байдлаар/

№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /%/
1	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	645,222	880,267,331	1,639	1,280	8.66
2	LEND	ЛЭНДМН ББСБ	9429256	640516404	54.5	45	-6.22
3	INV	ИНВЕКОР ББСБ	124,047	230,085,582	2,000	1,750	-3.49
4	GOV	ГОВЬ	719,304	203,022,769	295	277	-0.86
5	APU	АПУ	252,096	127,441,210	510	499	-0.29
6	ADB	АРД КРЕДИТ ББСБ	1,262,593	92,192,105	76	65	10.22
7	TTL	ТАВАН ТОЛГОЙ	13,801	92,146,915	6,850	6,470	-4.41
8	TUM	ТҮМЭН ШУВУУТ	392,239	63,515,036	174	145	-8.09
9	AIC	АРД ДААТГАЛ	77,965	55,126,358	745	630	9.61
10	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,241	27,000,025	5,450	4,805	-0.87
11	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	32,530	23,481,491	820	640	20.47
12	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	67,594	19,941,576	345	269	-17.15
13	MFC	МОНОС ХҮНС	296598	18771068.76	69	51	-13.07
14	MNP	МОНГОЛ ШУУДАН	27783	16882058.8	646	581	9.24
15	ITLS	АЙТҮҮЛС	211,890	16,467,784	80	75	-2.36
16	ADU	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	24183	16379725	746	650	0.28
17	SUL	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	152	15,367,440	112,900	94,000	-0.96
18	RMC	РЕМИКОН	463,424	10,700,617	28	22	-10.35
19	SUU	СҮҮ	55,675	10,615,744	205	170	4.34
20	GTL	ГУТАЛ	302	4,442,900	14,750	14,700	5.21



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2019.09.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /₮/	Өөрчлөлт /%/
			2019-08-31	2019-09-30		
1	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	32,530	670.00	807.18	137.18	20.47
2	СОР	242	977.00	1,135.00	158.00	16.17
3	ДАВААНБУЛАГ	1	171.00	196.65	25.65	15.00
4	БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	3	345.00	396.75	51.75	15.00
5	АРД КРЕДИТ ББСБ ХК	1,262,593	68.27	75.25	6.98	10.22
6	БЭРХ УУЛ	24	500.00	550.00	50.00	10.00
7	МОНГОЛ САВХИ	774	553.00	606.56	53.56	9.69
8	АРД ДААТГАЛ ХК	77,965	679.00	744.26	65.26	9.61
9	ШИВЭЭ ОВОО	245	2,380.00	2,600.00	220.00	9.24
10	МОНГОЛ ШУУДАН ХК	27,783	588.92	643.35	54.43	9.24
11	АТАР-ӨРГӨӨ	1	55,000.00	60,000.00	5,000.00	9.09
12	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	645,222	1,294.00	1,406.00	112.00	8.66
13	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	504	189.00	200.00	11.00	5.82
14	ГУТАЛ	302	14,020.00	14,750.00	730.00	5.21
15	МИК ХОЛДИНГ	120	13,700.00	14,390.00	690.00	5.04
16	МОГОЙН ГОЛ	24	8,620.00	9,000.00	380.00	4.41
17	СҮҮ	55,675	190.26	198.51	8.25	4.34
18	ХӨХ ГАН	22,565	70.00	72.07	2.07	2.96
19	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	7,952	500.00	510.00	10.00	2.00
20	ЖЕНКО ТУР БЮРО	20,784	70.00	71.37	1.37	1.96

Ханшийн бууралттай хувьцаа

/2019.09.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт /%/
			2019-08-31	2019-09-30		
1	АВТО ИМПЕКС	1,120	1,700.00	1,100.00	-600.00	-35.29
2	МОНГОЛ АЛТ	6	9,000.00	6,510.00	-2,490.00	-27.67
3	МОНГОЛ ШИЛТГЭЭН	5	350.00	270.00	-80.00	-22.86
4	МОНГОЛ БАЗАЛТ ХК	67,594	344.00	285.00	-59.00	-17.15
5	МЕРЕКС	2,015	24.00	20.00	-4.00	-16.67
6	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	46	128.03	108.00	-20.03	-15.64
7	МОНГОЛ СЕКЮРИТИЕС	103	400.00	340.00	-60.00	-15.00
8	ӨНДӨРХААН	20	1,923.00	1,635.00	-288.00	-14.98
9	МАТЕРИАЛИМПЕКС	266	7,000.00	6,000.00	-1,000.00	-14.29
10	ХИШИГ УУЛ	164	450.00	390.00	-60.00	-13.33
11	МОНОС ХҮНС	296,598	69.00	59.98	-9.02	-13.07
12	МОНИНЖБАР	501	115.00	100.00	-15.00	-13.04
13	БАГАНУУР	1,696	1,100.00	975.82	-124.18	-11.29
14	ДАРХАН ХҮНС	11	3,940.00	3,500.00	-440.00	-11.17
15	УБ-БҮК	1,968	429.00	382.00	-47.00	-10.96



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЖУРМЫГ ЯАРАЛТАЙ БАТЛАМЖЛУУЛАХ ХҮСЭЛТИЙГ СЗХ-НД ХҮРГҮҮЛЛЭЭ

Монголын хөрөнгийн зах зээл сүүлийн жилүүдэд идэвхжиж, үнэт цаас гаргагчдын тоо нэмэгдэж байгааг харгалзан зах зээлд урт хугацааны мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох зорилгоор МХБ нь “Хамтын хаалттай хөрөнгө оруулалттай сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын төслийг боловсруулж, СЗХ, зах зээлийн оролцогчид болон олон нийтийн саналуудыг тусгаж, 2019 оны 7 дугаар сарын 09-ний өдөр СЗХ-нд батламжлуулахаар хүргүүлсэн билээ.

Тус журмыг олон улсын стандарт болон дотоодын зах зээлийн хууль, дүрэм журмуудад нийцүүлэн боловсруулж, зах зээлийн оролцогчдын саналыг тусгаж олонтаа хэлэлцүүлсний үндсэнд СЗХ-нд хүргүүлсэн хэдий ч журам батламжлагдахгүй 2 сар гаруй хугацаа өнгөрөөд байгаа тул тус журмыг хугацаа алдалгүй батламжлуулах хүсэлтийг СЗХ-нд хүргүүлээ.

Энэхүү журам батламжлагдсанаар олон улсын биржүүдэд түгээмэл арилжигддаг бүтээгдэхүүн манай зах зээлд цоо шинээр нэвтэрч, хөрөнгө оруулагчдад эрсдлээ тараан байршуулж, багц хувьцаанд хөрөнгө оруулах боломжийг олгох төдийгүй зах зээлийг цаашид хөгжүүлэхэд нэн тулгамдаж буй хөрөнгө оруулалтын сангууд бий болох түлхүүр болох юм.

Үйл явдал

ЗАРИМ ГИШҮҮН КОМПАНИУДЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СЗХ-НООС ХҮЧИНГҮЙ БОЛГОЛОО

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 250 тоот тогтоолоор хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлээгүй дараах нэр бүхий 10 компанийн дилерийн болон андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна. Үүнд:

	Компанийн нэр	Тусгай зөвшөөрлийн төрөл
1	"Асе энд Т Капитал ҮЦК" ХХК	Дилер, андеррайтер
2	"Тэнгэр капитал ҮЦК" ХХК	Дилер, андеррайтер
3	"Эф Си Икс ҮЦК" ХХК	Андеррайтер
4	"Блүмсбюри секьюритис ҮЦК" ХХК	Андеррайтер
5	"Эм Ай Би Жи ҮЦК" ХХК	Андеррайтер
6	"Зэт Жи Би ҮЦК" ХХК	Андеррайтер
7	"Масдак ҮЦК" ХХК	Андеррайтер
8	"Блюскай секьюритиз ҮЦК" ХХК	Андеррайтер
9	"Өндөрхаан инвест ҮЦК" ХХК	Андеррайтер
10	"Батс ҮЦК" ХХК	Андеррайтер

Өнөөдрийн байдлаар МХБ нь гишүүн 51 компанитай бөгөөд энэхүү шийдвэрийн дагуу андеррайтерын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч гишүүн компанийн тоо 19, дилерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч гишүүн компанийн тоо 38 компани болж өөрчлөгдлөө.



"СҮҮ" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Сүү" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн №06 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 3 төгрөг 33 мөнгө буюу нийт 1,143,416,667 төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг тус компанийн 2019 онд хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр буюу 2019 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөр тогтоож, 2019 оны 9-р сарын 9-ний өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд "ҮЦТХТ" ТӨХК-аар дамжуулан тараахаар шийдвэрлэсэн байна.

"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН" ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН ӨРӨМДЛӨГИЙН 2-Р ШАТНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ЭХЛҮҮЛЛЭЭ

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн (TSX:ERD/MSE:ERDN) нь Хөндий Алтны Төсөл дээр 2019 оны өрөмдлөгийн хөтөлбөрийн 2-р үе шатыг эхлүүлсэн байна.

Тус компани нь 2019 оны 2-р улиралд хийсэн өрөмдлөгийн үр дүнд 5.9г/т агууламж бүхий 112 метр гүнд өрөмдлөг хийж, Баян Хөндий ордын төв хэсэгт, дөт гүнд алтны өндөр агууламж бүхий бүс үргэлжилж буйг баталгаажуулсан бөгөөд энэхүү шинээр эхлүүлж буй өрөмдлөгийн хөтөлбөрөөр тус бүсийг үргэлжлүүлэн шалгана гэж мэдэгдлээ.

"ТҮМЭН ШУВУУТ" ХК ОЛОН НИЙТЭЭС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН

Монголын хөрөнгийн биржид 2019 онд шинээр үнэт цаасаа бүртгүүлж, олон нийтээс 10 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн "Түмэн шувуут" ХК нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг 2019 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар дараах байдлаар зарцуулсан тухай тайлан ирүүлсэн байна. Үүнд:

- Өндөглөгч тахианы аж ахуйг өргөтгөх-1.8 тэрбум төгрөг;
- Шинээр 200,000 шувууны аж ахуй байгуулах-842 сая төгрөг;
- Сангасны бордооны үйлдвэр байгуулах-1.1 тэрбум төгрөг; Усалгаатай тариаланг өргөжүүлэх-889.2 сая төгрөг.

"АРД КРЕДИТ ББСБ" ХК ОЛОН НИЙТЭЭС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН ИРҮҮЛЛЭЭ

Монголын хөрөнгийн биржид 2019 онд шинээр үнэт цаасаа бүртгүүлж, олон нийтээс 5.2 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн "Ард Кредит ББСБ" ХК нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг 2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар дараах байдлаар зарцуулсан тухай тайлан ирүүлсэн байна. Үүнд:

- Зээл олголт-4.9 тэрбум төгрөг;
- Маркетингийн зардал -205.5 сая төгрөг;
- Мэргэжлийн байгууллагуудын төлбөр, шимтгэл, хураамж -276.5 сая төгрөг;
- Хэвлэл танилцуулганы зардал -54.4 сая төгрөг.



"АТАР ӨРГӨӨ" ХК-ИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР САНАЛ ЗАРЛАГДЛАА

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтад заасан "Компанийн хувьцаа эзэмшигч дангаараа буюу холбогдох этгээдтэй хамтран, эсхүл хувьцаа эзэмшдэггүй этгээд тухайн компанийн хувьцааг бүхэлд нь, эсхүл хувьцааны хяналтын багцаас дээш хувийг худалдан авахаар сайн дурын үндсэн дээр санал гаргана" гэж заасныг удирдлага болгон "Таван Богд Инвест" ХХК нь МХБ-ийн үнэт цаасны 2-р ангилалд бүртгэлтэй "Атар Өргөө" ХК-ийн 174,136 ширхэг энгийн хувьцаа буюу нийт энгийн хувьцааг 100 хувь худалдан авах саналыг нийтэд гаргалаа.

Санал гаргаж буй этгээд: "Таван Богд Инвест" ХХК

Санал болгож буй үнэ: 60,200 төгрөг

Худалдан авах тоо ширхэг: 174,136 ширхэг

Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа: 2019 оны 9 дүгээр сарын 26

Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа: 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 13:00 цаг

Хувьцааны худалдан авах төлбөрийг гүйцэтгэх хугацаа: 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр

Санал гаргагчийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг: 0 буюу 0 хувь

Санал гаргагчийн харилцагч үнэт цаасны компани: "Би Ди Сек ҮЦК" ХК, 75551919-04

Санал хүлээн авах хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион Оргил 1, Чингисийн өргөн чөлөө 6, Хаан банк цамхаг, 10-р давхар, Мэйл хаяг: invest@tavanbogd.com

"АРД КРЕДИТ ББСБ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Ард Кредит ББСБ" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 2019/23 тоот тогтоолын дагуу эчнээ санал хураалт явуулахаар болсон байна.

Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудал: "Ард Кредит ББСБ" ХК-ийн дүрмийг шинэчилсэн найруулгаар батлах

Эчнээ санал хураалтанд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2019 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр

Эчнээ санал хураалт явуулах хугацаа: 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 11-ний өдөр хүртэл

Эчнээ санал хураалтын материалтай танилцах: 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс өмнө ажлын өдрүүдэд 09-18 цагийн хооронд Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард санхүүгийн нэгдлийн байр, 2 давхар хаягаар эсвэл цахимаар ardcredit.shareholdersmeeting@gmail.com хаягаар саналаа ирүүлэх боломжтой.

Зохион байгуулах комисс: Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард санхүүгийн нэгдлийн байр, 2 давхар, Утас: 77003322, 80114871

Хувьцаа эзэмшигчид өөрийн биеэр эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан өөрийн харилцдаг үнэт цаасны компанид хандан санал авах хуудас бөглөх замаар эчнээ санал хураалтанд оролцох боломжтой.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN